

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2025/002/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2025 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Аудитор: Б.Үүрийнтуяа
Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА А.ГАЛИЯ ТАНАА

2025.05.14 № 328
тантай _____ -ны № _____ -т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдах байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

1. Санхүүгийн тайланд тусгасан 3,783.4 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, өмнөх ажиллаж байсан нягтлан бодогч нь санхүүгийн программыг хүлээлгэж өгөөгүйгээс санхүүгийн тайлан, зээлийн авлагын дэлгэрэнгүй бүртгэлийг шалгах, зээлийн авлагын үлдэгдлийг баталгаажуулах боломжгүй байна.

2. Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын гүйцэтгэл, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын хөтөлбөрүүдийн арга хэмжээнд зарцуулсан 2,526.2 сая төгрөгийн гүйцэтгэлийг хооронд нь гүйлгэн зарцуулснаас санхүүгийн тайлан, төсвийн хэлбэлзэл, дансны хуулгаар гарсан бодит гүйцэтгэл нь зөрүүтэй, санхүүгийн тайланг төсвийн хэлбэлзлээр гаргасан, 8.6 сая төгрөгийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан, хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй бөгөөд өргөн тархсан байна.

83250200004

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дах хэсгийн 6.3.2,16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.7, 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 5.1.2, 5.1.4, 8 дугаар зүйлийн 8.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2 дах хэсгийн 20.2.3, 20.2.6, 20.2.12, 20.2.13 дах заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, тасалбар болголт, толилуулга, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 2024 онд 2,712.2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 2,256.2 сая төгрөг зарцуулж, 93.1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгвалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.АЙГҮЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,676,367,792.00</u>	<u>3,783,372,555.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг	-	-
31140	Касс арилжааны банк	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
33	АВЛАГА	<u>2,676,367,792.00</u>	<u>3,783,372,555.00</u>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	400,000.00	
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага		
336	Зээлийн авлага	<u>2,675,967,792.00</u>	<u>3,783,372,555.00</u>
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	2,675,967,792.00	3,783,372,555.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	2,675,967,792.00	3,783,372,555.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,676,367,792.00</u>	<u>3,783,372,555.00</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	=
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
4136	Бусад өглөг	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,676,367,792.00</u>	<u>3,783,372,555.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,676,367,792.00	3,783,372,555.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	<u>2,676,367,792.00</u>	<u>3,783,372,555.00</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	2,106,023,906.00	2,676,367,792.00
51220	Тайлант үеийн үр дүн	570,343,886.00	1,107,004,763.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,676,367,792.00</u>	<u>3,783,372,555.00</u>

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	2,009,012,500.00	2,756,153,655.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,980,000.00	2,756,153,655.00
120	Нийтлэг татварын бус орлого	41,980,000.00	2,756,153,655.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	41,980,000.00	2,756,153,655.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,453,091,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	41,980,000.00	44,728,755.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		1,258,333,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,967,032,500.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,967,032,500.00	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,967,032,500.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,438,668,614.00	1,649,148,892.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,438,668,614.00	1,649,148,892.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,214,923.00	111,705,650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,214,923.00	111,705,650.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,338,453,691.00	1,537,443,242.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	579,852,476.00	446,497,549.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	579,852,476.00	446,497,549.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	400,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	400,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	758,601,215.00	1,090,545,693.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	758,601,215.00	1,090,545,693.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	570,343,886.00	1,107,004,763.00
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	-
145003	Хөрөнгө оруулалтын олз	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	570,343,886.00	1,107,004,763.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,010,956,500.00</u>	<u>2,756,553,655.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,924,000.00	2,756,553,655.00
120	Нийтлэг татварын бус орлого	43,924,000.00	2,756,553,655.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,924,000.00	2,756,553,655.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,453,091,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	41,980,000.00	44,728,755.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	1,944,000.00	1,258,733,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	1,967,032,500.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,967,032,500.00	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,967,032,500.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,502,068,614.00</u>	<u>3,617,148,892.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,502,068,614.00	3,617,148,892.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,214,923.00	111,705,650.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100,214,923.00	111,705,650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,214,923.00	111,705,650.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,401,853,691.00	3,505,443,242.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,642,852,476.00	2,414,497,549.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,642,852,476.00	2,414,497,549.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	400,000.00	400,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	400,000.00	400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	43,924,000.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,924,000.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	714,677,215.00	1,090,545,693.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	714,677,215.00	1,090,545,693.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(491,112,114.00)</u>	<u>(860,595,237.00)</u>
14	Бусад эх үүсвэр	491,112,114.00	860,595,237.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	491,112,114.00	860,595,237.00
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>491,112,114.00</u>	<u>860,595,237.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	
-----------	--	--

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл			2,106,023,906.00	2,106,023,906.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,106,023,906.00	2,106,023,906.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайланг үеийн үр дүн			570,343,886.00	570,343,886.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,676,367,792.00	2,676,367,792.00
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	2,676,367,792.00	2,676,367,792.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,676,367,792.00	2,676,367,792.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайланг үеийн үр дүн			1,107,004,763.00	1,107,004,763.00
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	3,783,372,555.00	3,783,372,555.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,712,224,900.00	2,526,203,199.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,712,224,900.00	2,526,203,199.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	127,450,000.00	111,705,650.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	127,450,000.00	111,705,650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	127,450,000.00	111,705,650.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,584,774,900.00	2,414,497,549.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,584,774,900.00	2,414,497,549.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,584,774,900.00	2,414,497,549.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,712,224,900.00	2,526,203,199.00

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,712,224,900.00	2,526,203,199.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,453,891,000.00	1,453,091,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,258,333,900.00	1,073,112,199.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зорилго нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйл ажиллагааны чанарыг сайжруулах, үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг зорилтот, бүлэг, хүн амд оновчтой хүргэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгох, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, монгол хүний амьдралын чанарыг сайжруулахад оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

- Орон нутгийн эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах
- Төр хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих
- Зорилтот бүлгийн иргэдийг мэргэжил олгох сургалтад хамруулан мэргэжилтэй болгож, ажлын байртай болгох
- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид мэргэжлээ зөв сонгосон байх
- Зорилтот бүлгийн иргэд ажил, мэргэжлийн чиг баримаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээ авсан байх
- Бүртгэлтэй ажилгүй иргэдийг ажилд зуучлан ажлын байртай болсон байх
- Санхүүгийн дэмжлэг болон ажлын байрны түрээсийн дэмжлэг авч хувиараа хөдөлмөр эрхлэх болсон иргэдийн тоо нэмэгдсэн байх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлсэн байна

Үйл ажиллагааны чиглэл: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байрыг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх сургалт, аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг, түр ажлын байрыг дэмжих зэрэг 4 арга хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзэв.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгээгүй байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын 2019 оны А/289 дүгээр тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгээгүй байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,107.0 сая төгрөгөөр буюу 41.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	2,676,367.80	3,783,372.56	1,107,004.76
Нийт хөрөнгө	2,676,367.80	3,783,372.56	1,107,004.76
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,676,367.80	3,783,372.56	1,107,004.76
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,676,367.80	3,783,372.56	1,107,004.76

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны авлага оны эцэст 3,783.3 сая төгрөгт хүрч оны эхнээс 1,107.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс санхүүгийн дэмжлэг олгосон зээлийн авлага 3,783.4 сая төгрөг байна.

Сангийн оны эхний зээлийн авлагаас 861.0 сая төгрөг төлөгдөж, шинээр 1,968.0 сая төгрөгийн зээл олгосон байна.

Сангийн жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийтдээ 3,783.4 сая төгрөгийн хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон зээлийн авлагатай байгаа боловч үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо нийлж баталгаажуулаагүй, өмнөх ажиллаж байсан нягтлан бодогч нь санхүүгийн программыг хүлээлгэж өгөөгүйгээс сангийн санхүүгийн тайлан, зээлийн авлагын дэлгэрэнгүй бүртгэлийг файлаар авч шалгаж тооцоо хийх, зээлийн авлагын үлдэгдлийг насжилтаар судалж гаргах боломжгүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн төслийг 3,893.4 сая төгрөгөөр боловсруулан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газраас улсын төсвөөс 1,453.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор, урьд оны үлдэгдлээс 1,258.3 сая төгрөгийг санхүүжүүлэхээр нийтдээ 2,712.2 сая төгрөгөөр баталж, төсвийн төслийн саналаас 1,181.2 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,453.9 сая төгрөгийн санхүүжилт, урьд оны үлдэгдлээс 1,258.3 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаандаа 2,526.2 сая төгрөгийг зарцуулж, 185.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 0.8 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,526.2 сая төгрөг буюу 93.1 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих				
80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	12,000.00	6,190.00	5,810.00	51.6
82602	ХБИ-ийн ажлын байрыг дэмжих	186,166.00	179,508.20	6,657.80	96.4
82616	ЗГ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	38,960.00	4,400.00	34,560.00	11.3
82619	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	55,044.50	39,149.25	15,895.25	71.1
82620	Хөдөлмөрт бэлтгэх сургалт	78,170.00	44,752.60	33,417.40	57.3
82621	Аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг	1,961,394.40	1,920,640.00	40,754.40	97.9
82622	Түр ажлын байрыг дэмжих	265,040.00	226,047.50	38,992.50	85.3
82623	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардал	115,450.00	105,515.65	9,934.35	91.4
НИЙТ ДҮН		2,712,224.90	2,526,203.20	186,021.70	93.1

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 онд батлагдсан төсвийн хүрээнд 65.2 сая төгрөгийн бараа материал худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 22 дүгээр албан бичгээр 01 дүгээр сарын 24-ний өдөр ирүүлсэн.

Тайлан ирүүлэхдээ сан түр хавсран гүйцэтгэж буй нягтлан бодогч нь 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр санхүүгийн тайланг нэгдүгээр гарын үсэггүй /дарга нь ээлжийн амралттай/ гэх шалтгаанаар Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан заавар, журам, аргачлалын дагуу дутуу гаргаж ирүүлсэн, сангийн 11,12 дугаар сарын 2 ширхэг санхүүгийн баримтыг хүлээлгэн өгч, 1-9-н сарын санхүүгийн баримт, бусад баримт материалуудыг өмнө нь ажиллаж байсан нягтлан бодогч нь хүлээлгэж өгөөгүй гэсэн тайлбар бичигтэй өгсөн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,438.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 21.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх шатанд материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,649.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 24.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус сангийн үйл ажиллагаатай холбоотой шалгахаар төлөвлөсөн шалгуур үзүүлэлтүүдээр горим сорил хэрэгжүүлж, хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

4.4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны веб сайтын мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,497,819.7 мянган төгрөгийн 33 гүйлгээ, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 81.1 хувьтай, өмнөх оны зөрчлийг давтан гаргасан.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

2.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Хугацаа хэтэрсэн авлага	1	28,032.5	1	28,032.5	100%
Шилэн дансны хуулийн хэрэгжилт 67.5 хувьтай байна 1	1	143,968.4	0	0	0
Нийт дүн	2	172000.9	1	28,032.5	50%

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар гарсан 1 зөвлөмж биелэгдэж, шилэн данстай холбоотой зөвлөмжийн дагуу зөрчлийг арилгасан боловч, зөрчлийг давтан гаргасан.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацааны хязгаарлалттай байдалтай холбоотой санхүүгийн тайлагнал, санхүүгийн баримтыг түүврийн аргаар эрсдэлд тооцож үзсэн тул хөтөлбөр арга хэмжээ, бусад зардал, авлагын зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн.

Дараагийн аудитаар сангийн нягтлан бодох бүртгэл хөтөлөлт, тайлагнал, авлагын дэлгэрэнгүй бүртгэл, тооцоо, хөтөлбөрийн зарцуулалтыг анхаарах шаардлагатай. Сангийн хөтөлбөр арга хэмжээний төсвийн зарцуулалтыг гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой залруулга гараагүй.

Аудитаар нийтдээ 7,900.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 8.0 сая төгрөгийн акт тогтоож, 7,892.3 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага өгөгдлөө.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлүүдэд үндэслэн Сөрөг санал дүгнэлт өгөгдсөнтэй холбоотой Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтын дагуу аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргад алба үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн тул Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 8.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн нэг акт тогтоосон. Үүнд:

1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2024 оны А/196 дугаар тушаалаар “Малчдыг малжуулах /хөтөлбөр/, үйл ажиллагааны удирдамж” батлагдсаны дагуу газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/10 дугаар тушаалаар баталсан ажлын хэсэг тайлант онд 160 иргэнд 1,280.0 сая төгрөгийг олгохоор хавсралтаар баталсан байна. Дээрх зээлийг аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг 82621 арга хэмжээнээс олгосноос хөтөлбөрт хамрагдаагүй 1 иргэнд 8.0 сая төгрөгийг олгож сангийн хөрөнгийн зориулалт бус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, 41 дүгээр зүйлийн 41.1-д “*Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ*”, 41.2 дахь хэсгийн 41.2.2-т “*батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах*”, 41.2 дахь хэсгийн 41.2.3-т “*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: *Эргэн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.*

5.2 Албан шаардлага

Аудитаар 7,892.3 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага өгөгдсөн. Үүнд:

1. Сангийн жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийтдээ 3,783.4 сая төгрөгийн хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон зээлийн авлагатай байгаа боловч үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо нийлж баталгаажуулаагүй, өмнөх ажиллаж байсан нягтлан бодогч нь санхүүгийн программыг хүлээлгэж өгөөгүйгээс сангийн санхүүгийн тайлан, зээлийн авлагын дэлгэрэнгүй бүртгэлийг файлаар авч шалгаж тооцоо хийх, зээлийн авлагын үлдэгдлийг насжилтаар судалж гаргах боломжгүй байна.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайланг сангийн мэргэжилтэн хавсран гүйцэтгэж байгаа бөгөөд санхүүгийн тайланг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр ирүүлэхдээ санхүүгийн баримтуудыг бүрэн ирүүлээгүй, өөрийн хариуцаж хийсэн 11-12 дугаар сарын санхүүгийн баримтыг хүлээлгэн өгсөн, 1-9-н сарын санхүүгийн баримтыг 2025 оны 2 дугаар сарын 24-ны өдөр ирүүлсэн, үүнээс шалтгаалж аудитаар төлөвлөсөн эрсдэлийн дагуу горим сорилыг хэрэгжүүлж, дүгнэлт гаргах цаг хугацаа хязгаарлагдсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д *“төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх”*, 16 дугаар зүйлийн 16.5.2 -т *“батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”*,

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл *“Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.....”*, 9 дүгээр зүйлийн *“Төсвийн байгууллага нь төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайланг тайлагнаж, тушаана”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан *“Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”*-тай нийцэхгүй, толилуулга, иж бүрэн байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: *Санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, зааврын дагуу үнэн зөв гаргах, зээлийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.*

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын гүйцэтгэл, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын хөтөлбөрүүдийн арга хэмжээнд зарцуулсан 2,526.2 сая төгрөгийн гүйцэтгэлийг хооронд нь гүйлгэн зарцуулсантай холбоотой санхүүгийн тайлан, төсвийн хэлбэлзэл, дансны хуулгаар гарсан бодит гүйцэтгэл нь зөрүүтэй байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг төсвийн хэлбэлзлээр гаргаж ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т *“батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”*, 54 дүгээр зүйл *“Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан”*, 54.5-д *“Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна”*, 54.5.1-д *“тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д *“1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө”*, 8 дугаар зүйл *“Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.....”*, 14 дүгээр зүйлийн 14.4-д *“Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”*, 14.4.5-д *“бүх орлого”*, 14.4.6-д *“бүх зардал”*, 14.4.7-д *“нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс”*, 20 дугаар зүйлийн 20.2.5-т *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”*, 41 дүгээр зүйлийн 41.1-д *“Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”*, 41.2 дахь хэсгийн 41.2.2-т *“батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”*,

41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалт, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-тай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн гүйцэтгэлийн тайланг журам, зааврын дагуу үнэн зөв гаргах, хөтөлбөрүүдийн арга хэмжээний зардлыг хооронд гүйлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага өгөв.

3. Нийтийг хамарсан ажил, хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрт хамрагдсан иргэнд 17.8 төгрөгийн цалин олгохдоо 1.8 сая төгрөгийн ашгийн татвар суутгаагүй олгосон, нийтийг хамарсан ажил, мод тарих ажлын цалингаас суутгаж авсан 0.5 төгрөгийн ашгийн татварыг төвлөрүүлж, санхүүгийн тайланд өглөгөөр харуулаагүй орхигдуулсан.

➤ Сангийн үйл ажиллагааны албан томилолтын зардалд нийтдээ 43.6 сая төгрөгийг зарцуулсан. Үүнээс хоолны зардалд 12.6 сая төгрөгийг олгосноос давхардсан тоогоор 393 хоногт албан хаагчдад олгосон хоолны зардлыг цалингийн сангаас олгосон хоолны хөнгөлөлтийн зөрүүгээр тооцож олгоогүй давхардуулан олгосон.

➤ Хөдөө суманд ажилласан томилолтын зардлын байрны зардалд 29.2 сая төгрөгийг олгож үүнээс суманд явсан байрны зардлаас томилолтоор ажиллаж ирсэн хоногоос 1 хоногийг хасаж тооцоогүй 32 албан хаагчид 4.1 сая төгрөгийг илүү олгосон, нийтлэг үйлчилгээний арга хэмжээний зардлаас 0.7 сая төгрөгийг онцгой байдлын аранзны хүнс бэлтгэхэд зориулалт бус зарцуулсан.

➤ Сангийн хөтөлбөр арга хэмжээгээ хэрэгжүүлэхэд гарсан үйл ажиллагааны зардал болох бичиг хэрэг, тээвэр шатахуун, аж ахуйн зардлуудад нийт 65.2 сая төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.7-д “Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 6.3.1-д “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 21-р зүйлийн 21.1-д “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар,..... тооцон албан татвар ногдуулна”, 25 дугаар зүйлийн 25.1-д “Энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч албан татвар ногдуулахад доор дурдсан журмыг баримтална”, 25.1.1-д “энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө”, 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3-т “бүх өр төлбөр”, 14.4.5-д “бүх орлого”, 14.4.6-д “бүх зардал”, 14.4.7-д “нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: гарсан зөрчил дутагдлыг арилгаж ажиллах талаар албан шаардлага өгөв.

4. Шилэн дансны веб сайтын мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,497.8 сая төгрөгийн 33 гүйлгээ, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 81.1 хувьтай ба өмнөх оны зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4-т “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, 5.1.4-т “мэдээллийг тогтмол шинэчилж байх”, 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор”, 6.4-т “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мэдээлээгүй 33 гүйлгээг шилэн дансанд нөхөн байршуулж, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаанд мэдээлж байх, зөрчлийг арилгаж ажиллах талаар албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Дээрх аудитын шийдвэрүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш нэг сарын дотор, биелэлтийг аймаг дахь төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

											шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан	1	8,000.0	1	8,000.0								
Сангийн жилийн эцсийн авлагын үлдэгдлийг баталгаажуулж ирүүлээгүй, зээлийн авлагын дэлгэрэнгүй бүртгэлийг ирүүлээгүйгээс авлагын үлдэгдлийг насжилтаар судалж гаргах боломжгүй	1	3,783,372.6			1	3,783,372.6						
Сангийн хөтөлбөр арга хэмжээний 2024 оны гүйцэтгэлийг хооронд нь гүйлгэн зарцуулсантай холбоотой бодит гүйцэтгэл нь зөрүүтэй гарсан.	1	2,526,203.2			1	2,526,203.2						
Хөтөлбөр арга хэмжээний зарим зардлуудыг давхардуулан олгосон, зориулалт бус зарцуулсан, шууд зардлаар тайлагнасан.	1	84,875.4			1	84,875.4						
Аудитаар илэрсэн алдаа зөрчлүүдэд үндэслэн Сөрөг санал дүгнэлт өгөгдсөнтэй холбоотой Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтын дагуу аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн.	1	0							1	0		
Дүн	5	6,402,451.2	1	8,000.0	3	6,393,817.2			1	0		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Шилэн дансны мэдээллийг дутуу мэдээлсэн, аудитын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн тайланг мэдээлээгүй.	1	1,497,819.7			1	1,497,819.7	
Дүн	1	1,497,819.7			1	1,497,819.7	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Дүн							
Нийт дүн	1	1,497,819.7			1	1,497,819.7	